

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ БОЛОН МӨНГӨ ХҮҮЛЭЛТТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилго нь банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн хүүгийн дээд хязгаарыг тогтоох, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2.1. Энэ хуулийн үйлчлэх хүрээнд банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээдээс бусад этгээдэд зээл олгох үйл ажиллагаа хамаарна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

3.1.1. “Зээлийн хүүгийн хязгаар” гэж банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээдээс тогтоож болох зээлийн хүүгийн дээд хэмжээг;

3.1.2. “Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээд” гэдэгт банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, ломбард зэрэг хуулийн этгээдийг;

3.1.3. “Мөнгө хүүлэлт” гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хязгаараас давсан зээлийн хүү тогтоохыг;

4 дүгээр зүйл. Зээлийн хүүгийн дээд хязгаар

4.1. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээдийн дараах төрлийн зээлийн дээд хязгаар нь дор дурьдсан хэмжээтэй байна:

4.1.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн 100 сая хүртэл төгрөгийн дүнтэй зээлийн дээд хязгаар - жилийн 18 хувь;

4.1.2. Цалингийн зээлийн дээд хязгаар жилийн - 18 хувь;

4.1.3. Тэтгэврийн зээлийн дээд хязгаар жилийн - 12 хувь;

4.1.4. Бусад бүх төрлийн зээлийн дээд хязгаар – жилийн 24 хувь;

5 дугаар зүйл. Зээлийн хүү тогтооход баримтлах зарчим

5.1. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээд өөрсдийн олгох зээлийн хүүг тогтооходоо дараахь зарчмыг баримтлана:

5.1.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжсэн 100 сая хүртэл төгрөгийн дүнтэй зээлийн хязгаарыг тогтооход Монгол банкны бодлогын хүү /зээлийн гэрээ байгуулсан өдрийн / дээр 7 хүртэл хувийг нэмж тооцох;

5.1.2. Цалингийн зээлийн хязгаарыг тогтооход Монгол банкны бодлогын хүү /зээлийн гэрээ байгуулсан өдрийн / дээр 7 хүртэл хувийг нэмж тооцох;

5.1.3. Тэтгэврийн зээлийн хязгаарыг тогтооходоо Монгол банкны бодлогын хүү /зээлийн гэрээ байгуулсан өдрийн / дээр 1 хувийг нэмж тооцох;

5.1.4. Бусад бүх төрлийн зээлийн хязгаарыг тогтооход Монгол банкны бодлогын хүү /зээлийн гэрээ байгуулсан өдрийн / дээр 13 хүртэл хувийг нэмж тооцох.

6 дугаар зүйл. Зээлийн үйл ажиллагаанд хориглох зүйл.

6.1. Зээлийн үйл ажиллагаанд дор дурдсан зүйлийг хориглоно:

6.1.1. Мөнгө хүүлэх;

6.1.2. Зээлийн хүүг урьдчилж авах;

6.1.3 Зээл гаргасны шимтгэл, зээл сунгасны шимтгэл, бэлэн мөнгө гаргасны шимтгэл, бусад төрлийн шимтгэл авах;

7 дугаар зүйл. Хяналт тавих, маргаан шийдвэрлэх

7.1. Энэ хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

8.1. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 11.32 дугаар зүйл нэмсүгэй:

“11.32 дугаар зүйл. Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль зөрчих

1. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд мөнгө хүүлэх үйл ажиллагаа явуулсан нь гэмт хэргийн шинжтэй биш бол иргэнийг хоёр мянга, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулна.

2. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь олгосон зээлийн хүүг урьдчилж авсан бол иргэнийг хоёр зуун нэгжтэй, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд зээл гаргасны төлөө аливаа шимтгэл, суутгал, зээл сунгасны болон бэлэн мөнгө гаргасны шимтгэл авсан бол иргэнийг таван зуун нэгжтэй, хуулийн этгээдийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулиар тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн зээлийн хүү тогтоон үйл ажиллагаа явуулсан бол иргэнийг мянган нэгжтэй, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 11.32 дугаар зүйл нэмсүгэй:

“11.32 дугаар зүйл. Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль зөрчих

1. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд мөнгө хүүлэх үйл ажиллагаа явуулсан нь гэмт хэргийн шинжтэй биш бол иргэнийг хоёр мянга, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулна.

2. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь олгосон зээлийн хүүг урьдчилж авсан бол иргэнийг хоёр зуун нэгжтэй, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд зээл гаргасны төлөө аливаа шимтгэл, суутгал, зээл сунгасны болон бэлэн мөнгө гаргасны шимтгэл авсан бол иргэнийг таван зуун нэгжтэй, хуулийн этгээдийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Банк, зээлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулиар тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн зээлийн хүү тогтоон үйл ажиллагаа явуулсан бол иргэнийг мянган нэгжтэй, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, зөрчлийг арилгуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**БАНК, ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО,
ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль" гэсний дараа "Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг дор дурдсан агуулгаар найруулсугай:

"3. Зээлийг заасан хугацаанд төлөөгүй бол зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд зээлийн үндсэн хүүг төлнө"

3 дугаар зүйл: Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай

4 дүгээр зүйл: Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

"24.4. Зээлийн хүүг тогтоохдоо Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж тогтоохыг хориглоно.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт " Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль" гэсний дараа "Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 282 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/282.4. Зээлийн гэрээгээр зээлийн хүүг тогтоохдоо Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж тогтоохыг хориглоно.

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн 282.4 дэх заалтын дугаарыг "282.5" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний хуулийн 286 дугаар зүйлийн 286.2 дахь хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

"286.2. Барьцаалан зээлдэх газраас олгох зээлийн хүүг талууд тохиролцон тогтооно. Зээлийн хүүг тогтоохдоо Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж тогтоохыг хориглоно.

4 дүгээр зүйл. Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.2 дахь хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

"452.2.Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу нэмэгдүүлсэн хүүг Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуульд заасан хязгаараас хэтрүүлэхгүйгээр төлөхөөр гэрээнд зааж болно. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй".

5 дугаар зүйл: Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.3 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

"452.3. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлийн хүүг тогтоохдоо Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуульд заасан хэмжээнээс хэтрүүлж тогтоохыг хориглоно".

6 дугаар зүйл: Иргэний хуулийн 452 дугаар зүйлийн 452.3 дахь хэсгийн дугаарыг "452.4" гэж өөрчилсүгэй.

7 дугаар зүйл: Энэ хуулийг 2018 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны .. дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль" гэсний дараа "Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

"10.1.Банк иргэн, хуулийн этгээдэд өөрийн болзол, нөхцөлийн дагуу зээл олгож болох бөгөөд зээлийн хүүг Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуульд зааснаас хэтрүүлэн тогтоож болохгүй".

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2018 оны .. дугаар сарын ..-ны өдөр баталсан Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ